

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН
2025 ОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026.01.12

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Зам, тээврийн сайд болон аймгын Засаг дарга нарын 2025 оны хамтын ажиллагааны гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулж яамны удирдлага, орон нутгийн Засаг дарга нарыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээний зорилго нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн чиглэлээр тусгагдсан бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн зам, тээврийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, хүн амын амьдралын таатай нөхцөлийг хангах, иргэдийн ая тухтай зорчих боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү гэрээгээр Зам, тээврийн сайд зам, тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн үйл ажиллагаанд салбарын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар орон нутагт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн ба аймгийн Засаг дарга нар авто зам, автотээвэр, агаарын тээвэр, төмөр зам, усан замын тээврийн чиглэлээр тодорхой үүргүүдийг хүлээсэн байна.

Зам, тээврийн сайдын 21 аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд нийт 473 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 247, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 165, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 23, хэрэгжих боломжгүй буюу үнэлгээнд тооцох боломжгүй 38 арга хэмжээ, дунджаар 75.4 хувьтай үнэлэгдэж байна.

Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг аймаг тус бүрээр авч үзвэл:

№	Аймаг	Нийт	Үнэлгээ (хувиар)				Хувь
			100	50	0	Хэрэгжих боломжгүй	
1.	Архангай	18	11	4	3	-	72.2
2.	Баян-Өлгий	21	16	5	-	-	88.1
3.	Баянхонгор	24	9	8	1	6	72.2
4.	Булган	26	10	13	1	2	62.5
5.	Говь-Алтай	19	9	10	-	-	73.6
6.	Говьсүмбэр	20	12	8	-	-	80.0
7.	Дархан-Уул	20	12	6	2	-	75.0
8.	Дорноговь	20	14	5	-	1	86.8
9.	Дорнод	28	19	9	-	-	83.9
10.	Дундговь	20	9	7	1	3	73.5
11.	Завхан	23	7	15	-	1	65.9
12.	Орхон	19	11	3	1	4	83.3
13.	Өвөрхангай	20	10	5	2	3	73.5
14.	Өмнөговь	25	17	6	1	1	83.3
15.	Сүхбаатар	26	6	11	1	8	63.9
16.	Сэлэнгэ	24	21	3	-	-	93.7
17.	Төв	21	7	12	2	-	61.9
18.	Увс	24	16	4	-	4	90.0
19.	Ховд	26	10	10	4	2	62.5
20.	Хөвсгөл	22	8	13	1	-	65.9
21.	Хэнтий	27	13	8	3	3	70.8
Нийт		473	247	165	23	38	75.4

Зам, тээврийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн үнэлгээний хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувиар өссөн байна. 2025 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт Сэлэнгэ аймаг хамгийн сайн буюу 93.7 хувиар үнэлэгдсэн бол Төв аймаг хамгийн бага буюу 61.9 хувиар үнэлэгдсэн байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

3.1. Нийтлэг байдлаар:

3.1.1. Зам, тээврийн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд биелэлт хангалтгүй, явц, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж улмаар биелэлтийг хангуулах талаар зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, гэрээ байгуулсан талуудын хамтын ажиллагаа сул зэрэг нөхцөл байдал тогтоогдлоо.

3.1.2. Мөн гэрээний хэрэгжилтийн үнэн бодит байдал хангагдаагүй, өмнөх оны хэрэгжилтийг хуулж тавьсан, зөв бичих дүрмийн алдаатай, байгууллагын нэрийг буруу бичсэн, тоо баримтгүй, мөнгөн дүнг ижил нэршлээр тайлагнаж хэвшээгүй зэрэг алдаа гаргасан байна.

3.1.3. Яамны бодлого зохицуулалтын газрууд нийтлэг байдлаар өмнөх оны гэрээний биелэлтийг үнэлж дүгнээгүй байхад дараа оны гэрээг байгуулснаар гэрээнд тусгах шаардлагагүй болон бүрэн хэрэгжсэн арга хэмжээг дахин төлөвлөх, тухайн аймгийн онцлог шинж, улс, орон нутгийн төсөвтэй уялдуулалгүй гэрээнд тусгаж байгаа нь жил бүр гэрээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх шалтгаан болж байна.

3.1.4. Өмнөх оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.5. Хэрэгжих боломжгүй 38 арга хэмжээнээс 15 арга хэмжээ нь төмөр замын салбарын, 17 арга хэмжээ нь иргэний нисэхийн салбарын чиглэлээр хийгдэх ажил байна.

3.1.6. Орон нутгийн захиргааны байгууллага нь зам, тээврийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд үзүүлж буй дэмжлэг бага, уялдаа холбоотой ажиллахгүй байгаа зэрэг нь гэрээний хэрэгжилтээс харагдаж байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсээр ирүүлсэн гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа биелэлт, тайлангаа хугацаа хоцроож ирүүлэх, нэхүүлэх зэргээр холбогдол өгдөггүй, гэрээнд туссан ажлыг зохион байгуулж ажилласан эсэх нь тодорхойгүй, мэдээ тайланг холбогдох газруудад ирүүлсэн мэтээр тайлагнадаг, зарим аймаг төлөвлөсөн арга хэмжээнээс зөрүүтэй биелэлт ирүүлж байна.

3.2. Аймаг:

Архангай аймаг: Зам, тээврийн сайдын Архангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 11, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 4, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 72.2 хувьтай байна. Үүнээс “Хот хооронд, орон нутгийн ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах асуудалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах”, “Ерөнхий зориулалтын нисэхэд байнга ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах талаар арга хэмжээ авч ажиллах” гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь орон нутаг дахь салбар байгууллагууд аймгийн Засаг даргын тамгын газрын хамтын ажиллагаа сул байгааг харуулж байна.

Баян-Өлгий: Зам, тээврийн сайдын Баян-Өлгий аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 16, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 5 арга хэмжээний дундаж үнэлгээ 88.1 хувьтай байна. Тус аймаг нь хамтын гэрээнд заасан арга хэмжээг хангалттай хэрэгжүүлж, тайлагнасан ч зөв бичих дүрэм, найруулга зүйн алдаа гаргасан байна.

Баянхонгор аймаг: Зам, тээврийн сайдын Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 9, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 8, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 6 арга хэмжээний дундаж үнэлгээ 77.2 хувьтай байна. Үүнд “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах” арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн боловч тусгай зөвшөөрөл олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтэд мэдээллээр хангах үүргийг хангаагүй, үр дүн харагдахгүй байгаа тул хэрэгжээгүйгээр үнэлэгдсэн байна.

Булган аймаг: Зам, тээврийн сайдын Булган аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 13, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 62.5 хувьтай байна. “Ерөнхий зориулалтын нисэхэд байнга ашиглах

агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах талаар арга хэмжээ авч ажиллах” арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлээгүй байна.

Говь-Алтай аймаг: Зам, тээврийн сайдын Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 9, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 10 арга хэмжээний дундаж үнэлгээ 73.7 хувьтай байна. Хамтын гэрээнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай хэмжээнд биелүүлж, тайлагнасан байна.

Говьсүмбэр аймаг: Зам, тээврийн сайдын Говьсүмбэр аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 12, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 8 арга хэмжээний дундаж үнэлгээ 80.0 хувьтай байна. Хамтын гэрээнд заасан арга хэмжээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн ч 4.6.1, 4.6.2 дахь заалтад ижил биелэлт ирүүлж хэрэгжилтийн хувийг ялгаатай ирүүлсэн байна.

Дархан-Уул аймаг: Зам, тээврийн сайдын Дархан аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 12, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 6, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 75.0 хувьтай байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” 189 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Олон улс, улсын чанартай авто зам дагуух ариун цэврийн байгууламж бүхий үйлчилгээний цогцолборын байршлын жагсаалт”-д дурдсан байршилд төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдэд газар олгох асуудлыг шийдэх, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг мэдээллээ улирал бүр гаргаж ирүүлэх” арга хэмжээнд газар олгох шийдвэр гаргасан эсэх, хэдэн байршилд ямар аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон, шийдвэрийн хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар бодитой биелэлт ирүүлээгүй, тухайн арга хэмжээнд холбогдолгүй тайлбар ирүүлсэн тул хэрэгжээгүй үнэлгээ өгсөн байна.

“Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах” арга хэмжээний хүрээнд 2022 оноос бэлтгэл ажлыг хийж эхэлсэн ч тайлант онд ямар ч ажил хийгдээгүй, арга хэмжээний зорилт хангагдаагүй тул хэрэгжээгүйгээр үнэлэгдсэн.

Дорноговь аймаг: Зам, тээврийн сайдын Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 14, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 5, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ 86.8 хувьтай байна.

Дорнод аймаг: Зам, тээврийн сайдын Дорнод аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 19, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 9 арга хэмжээний дундаж үнэлгээ 83.9 хувьтай байна. Хамтын гэрээнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай хэмжээнд биелүүлж, тайлагнасан ч зөв бичих дүрэм, найруулга зүйн алдаа гаргасан байна.

Дундговь аймаг: Зам, тээврийн сайдын Дундговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 9, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 7, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 3 арга

хэмжээний дундаж үнэлгээ 73.5 хувьтай байна. Хамтын гэрээнд заасан арга 4.4.3 дахь арга хэмжээний биелэлтэд өмнөх оны тайланг дахин ирүүлсэн байна.

Завхан аймаг: Зам, тээврийн сайдын Завхан аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 7, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 15, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ 65.9 хувийн хэрэгжилттэй байгаа ч төлөвлөгөөнд заасан арга хэмжээг тодорхой бус тайлагнасан. Тухайлбал ажлын явц хэдэн хувьтай, хэдэн төгрөг зарцуулсан нь тодорхойгүй, мөн холбоо хамааралгүй биелэлт ирүүлсэн, өмнөх оны биелэлтийг дахин ирүүлсэн зэрэг алдаатай байна.

Орхон аймаг: Зам, тээврийн сайдын Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 11, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 3, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 4 арга хэмжээний дундаж үнэлгээ 83.3 хувьтай байна.

“Улсын чанартай хатуу хучилттай авто замын зурвас газрыг тус яаманд эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум орон нутгийн 2025 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулж, эзэмшүүлэх асуудлаар хамтран ажиллах” арга хэмжээний хувьд 2024 оны хэрэгжилтээ дахин ирүүлсэн, 2025 онд хийгдсэн ямар нэг бодит ажил хийгдээгүй тул хэрэгжээгүй үнэлэгдсэн байна.

Өвөрхангай аймаг: Зам, тээврийн сайдын Өвөрхангай аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 5, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 2, хэрэгжих боломжгүй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 73.5 хувьтай байна.

“Хот хооронд, орон нутгийн ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих” арга хэмжээний хүрээнд ямар нэг ажил хийгдээгүй, хяналт, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул хэрэгжээгүй үнэлгээг өгсөн байна. “Өвөрхангай аймаг дахь “Хархорин” болон Хужирт сумын “Хужирт” нисэх буудлын аэродром орчмын аюулгүй бүсийн газрыг зохих журмын дагуу улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Өмнөговь аймаг: Зам, тээврийн сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 17, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 6, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ 83.3 хувьтай байна.

“Аймаг, орон нутагт автотээврийн хэрэгслийн ашиглалтаас хасагдсан аюултай хог хаягдал /шингэн болон бүх төрлийн аккумуляторын батарей/-ыг цуглуулах, хадгалах шаардлага хангасан цэгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран байгуулах, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр мэдээлэх” арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн ч тухайн ажил хийгдээгүй тул хэрэгжээгүй үнэлгээг өгсөн.

Сүхбаатар аймаг: Зам, тээврийн сайдын Сүхбаатар аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 6, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 11, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1, хэрэгжих боломжгүй 8 арга хэмжээний дундаж үнэлгээ 63.9 хувьтай байна.

“Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД30.01.04/-ийн 7 дугаар хавсралтад заасан “Нисэх онгоцны буудлын эдэлбэр газрын төлөвлөлтөд тавигдах шаардлага”-ын дагуу 3-7 дугаар зүйлд заасан объектуудыг байрлуулах асуудлыг холбогдох дээд байгууллагатай урьдчилан зөвшилцөх бөгөөд хогийн цэг, мал нядалгааны объект нисэх буудлын аэродромын хяналтын цэгээс 15 километрээс гадагш зайд шилжүүлэн байрлуулах, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авах” арга хэмжээний хүрээнд Нисэх буудлын аэродромын хяналтын цэгээс 15 км-ээс дотогш хогийн цэг болон мал нядалгааны объектууд байрлаж байгаа, одоогоор мах бэлтгэх, боловсруулах цэгүүдийг шилжүүлэх боломжгүй байгаа талаар дурдаж, гэрээний заалтаас түр хугацаанд хасах санал ирүүлсэн ч уг арга хэмжээний биелэлт хангалтгүй тул хэрэгжээгүйгээр үнэлэгдсэн.

Сэлэнгэ аймаг: Зам, тээврийн сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 21, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 93.7 хувьтай байна.

Төв аймаг: Зам, тээврийн сайдын Төв аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 7, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 12, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 61.9 хувьтай байна.

“Сум, орон нутагт автотээврийн хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний цахим үйлчилгээг нэвтрүүлэх бүртгэлийн байгууллагад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах асуудалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах” гэсэн 2 арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй ажил тайлагнасан байна.

Увс аймаг: Зам, тээврийн сайдын Увс аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 16, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 4, хэрэгжих боломжгүй 4 арга хэмжээний дундаж үнэлгээ 90.0 хувьтай байна.

Ховд аймаг: Зам, тээврийн сайдын Ховд аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 10, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 4, хэрэгжих боломжгүй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 62.5 хувьтай байна.

“Аймаг, орон нутагт автотээврийн хэрэгслийн ашиглалтаас хасагдсан аюултай хог хаягдал /шингэн болон бүх төрлийн аккумуляторын батарей/-ыг цуглуулах, хадгалах шаардлага хангасан цэгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран байгуулах, хэрэгжилтийн үр дүнг

улирал бүр мэдээлэх”, “Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2024 онд баталсан “Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх” төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр гаргаж ирүүлэх”, “Орон нутгийн нислэгийг сэргээх, нөхөн олговортой нислэг гүйцэтгүүлэх, нөхөн олговрын санхүүжилтийг аймгийн 2025 оны төсөвт тусгах”, “Монгол Улсын Их хурлын 2023 оны 93 дугаар тогтоол болон Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолд тус тус даалгасны дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэнд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг аймгийн 2025 оны төсвөөс санхүүжүүлэх” арга хэмжээний хүрээнд тодорхой ажил хийгдээгүй гэсэн биелэлт ирүүлсэн нь уг арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах талаар санал санаачилга гаргаж ажиллаагүй, гэрээний үүргийг биелүүлээгүй байна.

Хөвсгөл аймаг: Зам, тээврийн сайдын Хөвсгөл аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 8, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 13, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ 65.9 хувьтай байна.

“Монгол Улсын Их хурлын 2023 оны 93 дугаар тогтоол болон Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолд тус тус даалгасны дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэнд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг аймгийн 2025 оны төсвөөс санхүүжүүлэх” арга хэмжээний биелэлтийг ирүүлээгүй тул хэрэгжээгүй үнэлгээг өгсөн байна.

Хэнтий аймаг: Зам, тээврийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны хамтын ажиллагааны гэрээнд 5 зорилтын хүрээнд нийт 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 13, хэрэгжих шатанд буюу 50 хувийн биелэлттэй 8, хэрэгжээгүй болон биелэлт ирүүлээгүй 0 хувийн биелэлттэй 3, хэрэгжих боломжгүй 3 арга хэмжээний дундаж үнэлгээ 70.8 хувьтай байна.

“Улсын чанартай хатуу хучилттай авто замын зурвас газрыг тус яаманд эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум орон нутгийн 2025 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулж, эзэмшүүлэх асуудлаар хамтран ажиллах” арга хэмжээний хүрээнд холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт үүрэг чиглэл өгч ажилласан ч уг арга хэмжээний хүрээнд зорилт биелээгүй, “Монгол Улсын Их хурлын 2023 оны 93 дугаар тогтоол болон Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолд тус тус даалгасны дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэнд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг аймгийн 2025 оны төсвөөс санхүүжүүлэх” арга хэмжээний хүрээнд бодит биелэлт ирүүлээгүй, “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийн 7 дугаар хавсралтад заасан “Нисэх онгоцны буудлын эдэлбэр газрын төлөвлөлтөд тавигдах шаардлага”-ын дагуу 3-7 дугаар зүйлд заасан объектуудыг байрлуулах асуудлыг холбогдох дээд байгууллагатай урьдчилан зөвшилцөх бөгөөд хогийн цэг, мал нядалгааны объект нисэх буудлын аэродромын хяналтын цэгээс 15 километрээс гадагш зайд шилжүүлэн байрлуулах, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авах” арга хэмжээний хүрээнд ямар нэг ажил хийгдээгүй тул эдгээр арга хэмжээнд тус тус хэрэгжээгүй үнэлгээг өгсөн байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1. Зам, тээврийн сайд, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгах санхүү, хөрөнгө оруулалт шийдэж хийгдэх арга хэмжээний саналыг тухайн жилийн улс болон орон нутгийн төсөв батлагдахаас өмнө аймгуудад хүргүүлж хэвших;

4.2. Хамтран ажиллах гэрээнд тухайн салбарын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа тусгаж буй бодлого зохицуулалтын газрууд гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, баримтжуулан, бүрэн тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэх;

4.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хангуулах ажлын хүрээнд “хэрэгжих шатанд” буюу удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн 168, “хэрэгжээгүй” 23, “хэрэгжих боломжгүй” 38, нийт 229 арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоох, 2026 оны гэрээнд тусгагдах арга хэмжээнүүдийг заалт, хүрэх түвшин бүрээр нарийвчлан зөвшилцөж, нягтлан батлуулж, хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хамтарч ажиллахыг (4.1, 4.2, 4.3) бодлого, зохицуулалтын газруудад;

4.4. Гэрээний биелэлтийг төлөвлөсөн арга хэмжээний агуулга, дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан ажил, хүрсэн үр дүнг үнэн зөв, тодорхой, мөн гарсан шийдвэр, тоо баримт, огноо, нотлох баримтын хамт албан хэрэг хөтлөлтийн журмыг баримтлан тайлагнаж хэвшихийг аймгийн Засаг дарга нарт тус тус зөвлөж байна.

СХШУДАГ